



ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/08

Бор-Өндөр

Эрсдэлийн удирдлагын багийг шинэчлэн
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/120 дугаартай тушаалын хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын эрсдэлийг тодорхойлох, түүний нөлөөлөх үр дагаврыг үнэлэх, шийдвэр гаргах, хянан засварлах, тайлагнах, мэдээлэл солилцох төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зохион байгуулалт бүхий багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Эрсдэлийн удирдлагын багийн ахлагч:

Э.Түвшинсайхан

Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч

Эрсдэлийн удирдлагын багийн нарийн бичгийн дарга:

Б.Оюунтуяа

Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

Эрсдэлийн удирдлагын багийн гишүүн:

Ч.Саруулмөнх

Уурхайчин 4 дүгээр багийн Засаг дарга

2. Засаг даргын Тамгын газрын эрсдэлийг тодорхойлох, түүний нөлөөлөх үр дагаврыг үнэлэх, шийдвэр гаргах, хянан засварлах, тайлагнах, мэдээлэл солилцох төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, хагас бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн үүрэг болгосугай.

ДАРГА



З.УУГАНЖАРГАЛ